

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/204/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	2024 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК Захирал: Т.Хоролсүрэн Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com
-------------------------------	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
  - 4.1 Ерөнхий зүйл.....
  - 4.2 Материаллаг байдал.....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/81

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Мөн машин тоног төхөөрөмж 24,295.8 мянан төгрөгөөр, тавилга эд хогшил 15,608.4 мянган төгрөгөөр, нийт 39,904.2 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгджээ.

**5020302**

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 58,922.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагч 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 7 арга хэмжээг 100.0 хувь, 15 арга хэмжээг 70 хувь буюу нийт дүнгээр 72,1 хувиар биелүүлж биелэлтийг дээд байгууллагад хүргүүлснээр, дээд байгууллагаас 85 хувиар дүгнэгдсэн.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>173,698,726.43</b>	<b>220,703,551.65</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>114,711,399.57</b>	<b>142,438,498.69</b>
<b>312</b>	Банкинд байгаа мөнгө	114,711,399.57	142,438,498.69
<b>3121</b>	Төгрөг	114,711,399.57	142,438,498.69
31211	Төрийн сангийн харилцах	114,711,399.57	142,438,498.69
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		5,634,446.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		5,634,446.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,987,326.86	72,630,606.96
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	6,026,022.50	49,911,917.96
35110	Тусгай зориулалттай материал		29,100,836.66
35130	Эм боох материал	6,026,022.50	20,811,081.30
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	52,961,304.36	22,718,689.00
35410	Бичиг хэргийн материал	1,991,200.00	2,515,200.00
35420	Аж ахуйн материал	10,461,200.00	10,424,900.00
35460	Хүнсний материал	1,154,000.00	1,403,000.00
35470	Бусад хангамжийн материал	39,354,904.36	8,375,589.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>591,333,985.19</b>	<b>581,148,236.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	591,333,985.19	581,148,236.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	584,327,985.19	574,142,236.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	435,666,064.88	435,666,064.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,999,240.56	-42,723,366.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,260,000.00	51,260,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,468,333.36	-17,885,000.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	231,557,608.28	255,853,434.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-117,450,639.73	-141,552,747.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,932,350.00	56,540,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,169,824.32	-23,016,848.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,989,000.00	1,989,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,989,000.00	-1,989,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,006,000.00	7,006,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,456,000.00	7,456,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>765,032,711.62</b>	<b>801,851,788.26</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>765,032,711.62</b>	<b>801,851,788.26</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	765,032,711.62	801,851,788.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,933,621.64	296,933,621.64
51101	Өмч: - төрийн	296,933,621.64	296,933,621.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	409,449,135.95	446,268,212.59
51210	Өмнөх үеийн үр дүн	409,449,135.95	409,449,135.95
51220	Тайлант үеийн үр дүн		36,819,076.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,649,954.03	58,649,954.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>765,032,711.62</b>	<b>801,851,788.26</b>

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ



Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	667,271,287.50	717,575,463.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,577,617.50	27,080,795.50
120	Нийтлэг татварын бус орлого	102,577,617.50	27,080,795.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,577,617.50	27,080,795.50
120004 2	Туслах үйл ажиллагааны орлого	32,212,501.85	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	564,693,670.00	690,494,668.31
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,510,000.00	28,131,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,510,000.00	28,131,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	549,183,670.00	662,362,768.31
134002	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих	549,183,670.00	662,362,768.31
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	592,355,131.77	680,756,387.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	592,355,131.77	680,756,387.17
2101	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,413,127.77	669,533,181.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,053,727.92	371,583,282.31
210101	Үндсэн цалин	202,053,480.09	193,208,429.58
210102	Нэмэгдэл	77,909,520.83	143,412,489.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,402,835.00	3,815,841.00
210104	Урамшуулал	23,687,892.00	31,146,522.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,570,048.53	46,034,465.88
210201	Тэтгэврийн даатгал	23,701,012.85	31,561,119.39
210202	Тэтгэмжийн даатгал	2,512,669.78	3,716,308.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,988,978.91	2,973,046.76
210204	Ажилгүйдлийн даатгал	805,895.99	695,097.99
210205	Эрүүл мэндийн даатгал	5,561,491.00	7,088,893.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,067,996.00	15,408,694.50
210301	Гэрэл, цахилгаан	2,124,119.00	2,103,003.50
210302	Түлш, халаалт	10,944,077.00	13,305,691.00
210303	Цэвэр, бохир ус	999,800.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	75,427,907.00	119,332,479.00
210401	Бичиг хэрэг	00.00	180,000.00
210402	Тээвэр, шатахуун	31,882,450.00	37,993,620.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,496,800.00	1,406,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	310,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,794,637.00	68,927,841.82
2105	Нормативт зардал	69,997,842.00	57,913,793.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,344,842.00	42,870,993.20
210502	Хоол, хүнс	13,653,000.00	15,042,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	
210604	Урсгал засвар	200,000.00	
2107	Томилолт, зочны зардал	2,112,000.00	3,616,000.00
210702	Дотоод албан томилолт	2,112,000.00	3,616,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,598,577.85	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,598,577.85	

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,385,028.47</b>	<b>55,644,466.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,736,416.00	5,554,542.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,648,612.47	50,089,924.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>942,004.00</b>	<b>11,223,205.50</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>942,004.00</b>	<b>11,223,205.50</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	942,004.00	11,223,205.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>74,916,155.73</b>	<b>36,819,076.64</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>74,916,155.73</b>	<b>36,819,076.64</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>781,492,671.85</b>	<b>684,860,222.31</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>749,280,170.00</b>	<b>684,860,222.31</b>
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	184,586,500.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>15,510,000.00</b>	<b>28,131,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,510,000.00	28,131,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангаас санхүүжих</b>	<b>549,183,670.00</b>	<b>656,728,322.31</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	549,183,670.00	656,728,322.31
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>578,835,572.28</b>	<b>631,804,973.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>578,835,572.28</b>	<b>631,804,973.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>577,893,568.28</b>	<b>620,581,767.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>301,120,634.25</b>	<b>373,780,511.96</b>
210101	Үндсэн цалин	194,976,462.42	189,409,581.23
210102	Нэмэгдэл	78,168,679.83	149,403,567.47
210103	Хоол унааны хөнгөлөлт	3,402,000.00	3,820,841.00
210104	Урамшуулал	24,573,492.00	31,146,522.26
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,437,587.53</b>	<b>43,837,236.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,166,500.25	29,736,284.93
210202	Тэтгэмжийн даатгал	3,028,379.78	3,501,621.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,376,553.78	2,801,297.40
210204	Ажилгүйдлийн даатгал	594,188.99	709,139.08
210205	Эрүүл мэндийн даатгал	5,271,964.73	7,088,893.07
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,068,196.00</b>	<b>15,408,694.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,124,119.00	2,103,003.50
210302	Түлш, халаалт	10,944,077.00	13,305,691.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,769,560.00</b>	<b>56,116,788.00</b>
210401	Бичиг хэрэг	3,198,000.00	6,200,000.00
210402	Тээвэр шатахуун	29,990,510.00	37,993,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,496,800.00	1,526,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	310,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,364,250.00	10,086,368.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,722,474.50</b>	<b>93,418,952.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,926,974.50	71,627,152.00
210502	Хоол, хүнс	10,295,600.00	15,291,800.00

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ



Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,499,900.00	6,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,590,550.00</b>	<b>15,928,600.00</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	17,109,900.00	435,000.00
210604	Урсгал засвар	2,480,650.00	15,493,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,112,000.00</b>	<b>3,616,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,112,000.00	3,616,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>98,768,600.00</b>	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,440,600.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,303,966.00</b>	<b>18,474,985.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,303,966.00	18,474,985.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>942,004.00</b>	<b>11,223,205.50</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>942,004.00</b>	<b>11,223,205.50</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	942,004.00	11,223,205.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>202,657,099.57</b>	<b>53,055,249.12</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>86,945,900.00</b>	<b>25,328,150.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>86,945,900.00</b>	<b>25,328,150.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>86,945,900.00</b>	<b>25,328,150.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	86,945,900.00	25,328,150.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-86,945,900.00</b>	<b>-25,328,150.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>115,711,199.57</b>	<b>27,727,099.12</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>114,711,399.57</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>114,711,399.57</b>	<b>142,438,498.69</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	58,649,954.03	334,532,980.22	690,116,555.89
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,933,621.64	58,649,954.03	334,532,980.22	690,116,555.89
3	Тайлант үеийн үр дүн			74,916,155.73	74,916,155.73
4	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	58,649,954.03	409,449,135.95	765,032,711.62

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ



Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,933,621.64			58,649,954.03	409,449,135.95	765,032,711.62
6	Тайлант үеийн үр дүн					36,819,076.64	36,819,076.64
7	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64			58,649,954.03	446,268,212.59	801,851,788.26

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/төгрөг/ Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	895,438,200.00	645,909,917.69	249,528,282.31	72.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	895,438,200.00	645,909,917.69	249,528,282.31	72.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	895,438,200.00	645,909,917.69	249,528,282.31	72.1
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	545,506,500.00	373,780,511.96	171,725,988.04	68.5
210101	Үндсэн цалин	263,670,400.00	189,409,581.23	74,260,818.77	71.8
210102	Нэмэгдэл	201,428,100.00	149,403,567.47	52,024,532.53	74.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,982,900.00	3,820,841.00	1,162,059.00	
210104	Урамшуулал	75,425,100.00	31,146,522.26	44,278,577.74	41.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,188,200.00	43,837,236.23	24,350,963.77	64.3
210201	Тэтгэврийн даатгал	46,368,100.00	29,736,284.93	16,631,815.07	64.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,454,800.00	3,501,621.75	1,953,178.25	64.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,364,000.00	2,801,297.40	1,562,702.60	64.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,091,100.00	709,139.08	381,960.92	65.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,910,200.00	7,088,893.07	3,821,306.93	65.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,631,900.00	15,408,694.50	11,223,205.50	
210301	Гэрэл, цахилгаан	3591500	2,103,003.50	1,488,496.50	58.6
210302	Түлш, халаалт	21840400	13,305,691.00	8,534,709.00	60.9
210303	Цэвэр бохир ус	1200000		1,200,000.00	
2104	<b>Хангамж бараа материал</b>	70,694,000.00	56,116,788.00	14,577,212.00	79.4
210401	Бичиг хэрэг	6,200,000.00	6,200,000.00		100.0
210402	Тээвэр шатахуун	49,902,900.00	37,993,620.00	11,909,280.00	76.1
210403	Шуудан холбоо	2,016,000.00	1,526,800.00	489,200.00	75.7
210405	Хог хаягдал	1,874,700.00	310,000.00	1,564,700.00	16.5
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	10,700,400.00	10,086,368.00	614,032.00	94.3
2105	<b>Нормативт зардал</b>	108,742,800.00	93,418,952.00	15,323,848.00	85.9
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	79,040,000.00	71,627,152.00	7,412,848.00	90.6
210502	Хоол, хүнс	23,202,800.00	15,291,800.00	7,911,000.00	65.9

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Нормын хувцас зөөлөн эдлэл	6,500,000.00	6,500,000.00		100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40,961,400.00</b>	<b>39,768,400.00</b>	<b>1,193,000.00</b>	<b>97.1</b>
210601	Багаж техник хэрэгсэл	15,461,400.00	14,274,800.00	1,186,600.00	92.3
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00		100.0
210604	Урсгал засвар	15,500,000.00	15,493,600.00	6,400.00	100.0
2107	<b>Томилолт зочны зардал</b>	<b>4,750,000.00</b>	<b>3,616,000.00</b>	<b>1,134,000.00</b>	<b>76.1</b>
210702	Дотоод албан томилолт	4,750,000.00	3,616,000.00	1,134,000.00	76.1
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,963,400.00</b>	<b>19,963,335.00</b>	<b>65.00</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,963,400.00	19,963,335.00	65.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,000,000.00</b>	<b>-</b>	<b>10,000,000.00</b>	
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,000,000.00</b>	<b>-</b>	<b>10,000,000.00</b>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	-	10,000,000.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>895,438,200.00</b>	<b>673,637,016.81</b>	<b>221,801,183.19</b>	<b>75.20</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,131,900.00</b>	<b>16,908,694.50</b>	<b>11,223,205.50</b>	<b>60.1</b>
132001	Орон нутгийн төсвөөс	28,131,900.00	16,908,694.50	11,223,205.50	60.1
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>895,438,200.00</b>	<b>656,728,322.31</b>	<b>238,709,877.69</b>	<b>73.3</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	895,438,200.00	656,728,322.31	238,709,877.69	73.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	114,711,399.57	-114,711,399.57	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	142,438,498.69	-142,438,498.69	
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>22</b>	<b>20</b>	<b>2</b>	<b>90.9</b>
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	15	1	93.8
620003	Үйлчлэх ажилтан	5	4	1	80.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн зорилт, зорилго үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сумын иргэдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж чанар хүртээмжийг сайжруулан, иргэдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж, хүн амд эрүүл аж төрөх зан үйлчилгээг төлөвшүүлэх, эмчилгээ оншилгооны орчин үеийн аргыг нэвтрүүлснээр хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх.

### 3.1.1.1 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянговь сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний 240,241 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны 08 тоот тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,819.1 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
1	Мөнгөн хөрөнгө	114,711.4	142,438.5	27,727.1
2	Авлага	-	5,634.4	5,634.4
3	Бараа материал	58,987.3	72,630.6	13,643.3
4	Үндсэн хөрөнгө	768,861.0	808,765.2	39,904.2
5	Хуримтлагдсан элэгдэл	(177,527.0)	(227,617.0)	(50,089.9)
<b>5</b>	<b>Нийт хөрөнгө</b>	<b>765,032.7</b>	<b>801,851.8</b>	<b>36,819.1</b>
6	Засгийн газрын хувь оролцоо	765,032.7	801,851.8	36,819.1
<b>7</b>	<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>765,032.7</b>	<b>801,851.8</b>	<b>36,819.1</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 142,438.5 мянган төгрөг болж 27,727.1 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтын үлдэгдэл 5,634.4 мянган төгрөгөөр авлагын дансны үлдэгдэл нэмэгдсэн байна .
- Бараа материал дансны үлдэгдэл 72,630.6 мянган төгрөг болж 13,643.3 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 30,979.3 мянган төгрөгөөр буурч, тусгай зориулалтай материал 29,100.8 мянган төгрөг, эм, боох материал 14,785.1 мянган төгрөг, аж ахуйн материал 736.7 мянган төгрөгөөр бараа материалын үлдэгдэл өссөхөд нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 581,148.2 мянган төгрөг болж 10,185.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж 9,719.8 мянган төгрөг, тавилга эд хогшил 15,608.4 мянган төгрөгөөр худалдаж авсан, үнэ төлбөргүй шилжиж ирсэн машин тоног төхөөрөмж 14,576.0 мянган төгрөг. тайлант хугацааны элэгдлийн зардал 50,089.9 мянган төгрөг гарсантай холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 801,858.8 мянган төгрөг болж 36,819.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 50,304.3 мянган төгрөгөөр, нийт зардал өмнөх оноос 88,401.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын 895,438.2 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 28,131.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг 656,728.3 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 28,131.9 мянган төгрөгөөр баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 895,438.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 28,131.9 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 656,728.3 мянган, орон нутгийн төсвөөс 28,131.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 417,617.7 мянган, нормативт зардалд 93,418.9 мянган, бусад урсгал шилжүүлэгийн зардалд 19,963.4 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 98,001.2 мянган, нийт 629,001.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс байр ашиглалтын зардалд 15,408.7 мянган, эд хогшил, урсгал засварын зардалд 1,500.0 мянган, нийт 16,908.7 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 11,223.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71601	Ерөнхий боловсролын сургалт	895,438.2	645,909.9	249,528.30	72.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	760,569.4	527,945.30	232,624.10	69.4
80802	Урсгал шилжүүлэг	19,963.4	19,963.40		100.0
83112	Бараа үйлчилгээний бусад зардал	114,905.4	98,001.20	16,904.20	85.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнд 44,552.6 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 37,993.6 мянган төгрөгийг зарцуулсан байна., хүнсний материалын 46,590.3 мянган төгрөгийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар харин бусад эм, эмнэлгийн хэрэгсэл 59,438.6 мянган төгрөг, хангамж бичиг хэргийн 94,577.1 мянган төгрөгийн бараа материал, тавилга эд хогшлыг шууд худалдан авалтын аргаар, тоног төхөөрөмж 9,719.8 мянган төгрөгийн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдаж авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын

БНА-2024/204/НА-СТА-ТШЗ

31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 875,580.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,755.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материалаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 6,129.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 196,076.9 мянган, нормативт зардалд 15,323.8 мянган төгрөгийн зарлуудыг хэмнэж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусд нь салгах ёстой гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 653,588.9 мянган төгрөгийн 110 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 58,987.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 26.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	58,987.3	1	58,987.3	100
Зөвлөмж	2	26.3	2	26.3	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>59,013.6</b>	<b>3</b>	<b>59,013.6</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Тус төв нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу байгууллагын хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм, журмыг зөрчөөгүй 2023 оны

санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа, зөрчил илэрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөх санал хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.